

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР 151021-4
ХАВСРАЛТ 1
ОГНОО 2022 оны 02-р сарын 21-ний өдөр
УТГА Охин компани үүсгэн байгуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн одоогийн импорт, цаашдын экспортын үйл ажиллагааг ил тод, зөв менежменттэй зохион байгуулах зорилгоор Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани шинээр үүсгэн байгуулах асуудлыг авч хэлэлцээд Компанийн Дүрмийн 9.4.13-р зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай Монгол хэлээр Сэнтрал Коммерс ХХК, Англи хэлээр Central Commerce LLC-ийг үүсгэн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Сэнтрал Коммерс ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
 - a. Экспорт ба импортын үйл ажиллагаа; болон
 - b. Бөөний ба жижиглэнгийн худалдаа.
3. Сэнтрал Коммерс ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээг 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 (арван мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдсэн 1,000,000 (нэг сая) төгрөгөөр баталсугай.
4. Сэнтрал Коммерс ХХК-ийн албан ёсны хаяг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхар хаягт байхаар тогтсугай.
5. Сэнтрал Коммерс ХХК-ийн дүрмийг Хавсралт 1-ээр баталсугай.
6. Сэнтрал Коммерс ХХК-ийн дүрмийг Компанийг төлөөлөн баталгаажуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-т зөвшөөрсүгэй.
7. Сэнтрал Коммерс ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон үйл ажиллагааны зардалд шаардлагатай хөрөнгө оруулалтыг Сэнтрал Коммерс ХХК-д оруулахыг Компанийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.
8. Сэнтрал Коммерс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Ганболд овогтой Чинзориг (Т386050612)-ийг 2022 оны 02-р сарын 21-ний өдрөөс эхлэн томилсугай.
9. Сэнтрал Коммерс ХХК-ийн нэр дээр аливаа банканд харилцах данс нээлгэх, данснаас гүйлгээ хийх эрх бүхий этгээдийг тохилох эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.

ДУГААР 151021-4
ОГНОО 2022 оны 02-р сарын 21-ний өдөр

10. Сэнтрал Коммерс ХХК-ийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх, хяналтын дугаар авах, тамга тэмдэг авах зэргийг оролцуулаад дээрх шийдвэрүүдийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай ба/буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ДУГААР
ОГНОО

151021-4
2022 оны 02-р сарын 21-ний өдөр

		ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		 <p>CENTRAL EXPRESS CVS JSC СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК УЛААНБААТАР ХОТ 9022010245 6166804 ШЖР0471</p>	
	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД			
	Ч.МЭРГЭН			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ:		100%		